

БАТЛАВ
“ЭРДЭНЭТ”
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



ТӨҮГ-ЫН
Т.БАТМОНХ

2024 .. оны 11 дугаар сарын 21.....
ОРХОН АЙМАГ

**МОД УРЖҮҮЛГИЙН ГАЗАР БАЙГУУЛАХ АЖИЛ - ЭҮТӨҮГ/202401011287
БАГЦ №2. ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС, ЖИМС ЖИМСГЭНИЙ ТАЛБАЙД ИЖ
БҮРЭН УСАЛГААНЫ СИСТЕМ СУУРИЛУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.	Захиалагч компанийн нэр	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ
2.	Техникийн тодорхойлолт боловсруулах зорилго	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь 2031 он хүртэл 100 сая мод тарьж ургуулах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ногоон хөгжлийн төслийн нэгжийн харьяа 134 га талбай бүхий Мод уржуулгийн Эрдэнэт цогцолборт усалгааны систем суурилуулах
3.	Эрх зүйн үндэслэл	МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлиг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, 2021 оны 12 сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтооолор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 350 дугаар тогтоол, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, 2031 он хүртэл 100 сая мод тарьж, ургуулах, арчлан хамгаалах 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн батламж, үйлдвэрийн газрын 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан 2031 он хүртэл 100 сая мод тарьж, ургуулах, арчлан хамгаалах төлөвлөгөө, ШУА-ийн Ботаникийн цэцэрлэг хүрээлэн гүйцэтгэж 2023 оны 09 сарын 06-ны батлагдсан Хангайн бүсэд мод үржүүлгийн газар байгуулах ТЭЗҮ
4.	Талбайн нэр, байршил	Булган аймгийн Сэлэнгэ сумын III багийн нутаг, газрын нэр Шар тал, газрын гадаргуу тэгш, налуу 1-2 градус, элсэргэг хөрстэй
5.	Ажлын хэмжээ	1. Алим /12 га/ 2. Хөх даланхальс /10 га/

		<ol style="list-style-type: none"> 3. Интоор /10 га/ 4. Чавга /9.2 га/ 5. Үндсэн хамгаалалтын зурvas /3800м, 3 эгнээ/ 6. Туслах хамгаалалтын зурvas /3000м/ 7. Үрийн болон эх мод /10 га/ 8. Туршилт судалгаа /5 га/ 9. Бойжуулах талбай /5.3 га/ 10. Ховор ургамал /3.9 га/ 11. Цуглуулга /1.8 га/ 12. Гоёл чимэглэл /1.5 га/ нийт 12 хэсгээс бүрдэнэ
6.	Хууль зүй ба хуулийн хэрэгжилт	Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний бүхий л хүрээнд үйлчлэх Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоор тавигдах шаардлагууд, мөн энэхүү бичиг баримтад тусгайлан заасан үйл ажиллагааны дүрэм, стандарт, бусад тогтоол, шийдвэр, журмууд, (зөвхөн үүгээр хязгаарлахгүй бусад) хууль тогтоомжоор дагаж гарсан шаардлагуудад нийцүүлж ажиллана.

2. ЗАХИАЛАГЧ БА ГҮЙЦЭТГЭГЧИЙН ҮҮРЭГ

1	Төсөл хэрэгжүүлэгчид тавих шаардлага	<ul style="list-style-type: none"> - Мод тарьсан талбай, ойжуулалт, мод үржүүлгийн газар усалгааны систем суурилуулсан 5 хүртэл жилийн ажлын туршлагатай, түүнийгээ баримт, гэрээ бусад зүйлээр нотолсон байх - Усалгааны тоног төхөөрөмжийн худалдаа, угсралтын чиглэлийн эрх бүхий компани байх - Ажил гүйцэтгэхэд шаардлагатай техник багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй, усны мэргэжилтэн эсвэл ойн инженер, мэргэшсэн хүний нөөцтэй байх - Ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх ур чадвартай, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байх - Усалгааны системд хэрэглэгдэх материал, тоноглолууд нь 3-5 жил ашиглагдах чанарын шаардлага хангах
2	Хийгдэх ажлууд	<ul style="list-style-type: none"> - Усалгааны эх үүсвэр, шаардлагатай усны хэмжээг тодорхойлж хэрэгцээг хангах насос бүхий систем суурилуулах, схем зураг боловсруулах - Талбай бүрт тохирсон усалгааны систем байгуулах - Суулгац болон үрээр тарьсан талбай бүрт тохирсон усалгааны стандарт, нормыг баримтлах
3	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, эрсдэлийн менежмент	<ul style="list-style-type: none"> ✓ Үйл ажиллагааны үеийн Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хэрэгжүүлэгч компани бүрэн сахин хариуцна ✓ Эрүүл ахуйн шаардлага, стандарт, хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэн ажиллана ✓ Аюулгүй ажиллагааг хангаж, эрсдлээс урьдчилан сэргийлнэ
4	Тайлан	Тайлан Монгол хэлээр цахим болон цаасан хэлбэртэй байна. Ажлыг хүлээлгэж өгөхдөө эцсийн тайланг хамгаалах
5	Хугацаа	<ul style="list-style-type: none"> ✓ Гэрээ хийгдсэнээс хойш 60 хоногийн хугацаанд дуусгаж хүлээлгэн өгнө.
6	Хяналт	<ul style="list-style-type: none"> ✓ Захиалагч талыг төлөөлж “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ногоон хөгжил төслийн нэгж ажлын явцад байнгын хяналт тавина ✓ Гүйцэтгэгч тал захиалагч талын эрх бүхий албан тушаалтны тавьсан шаардлагыг хамтран хэлэлцэж хугацаанд нь шийдвэрлэнэ

		<ul style="list-style-type: none"> ○ Тарилтын схем 0,2м*0,2м, дуслын усалгаа суурилуулах - <u>XII дугаар хэсэг</u>-Гоёл чимэглэл 1,5 га ○ Тарилтын схем 0,2м*0,2м, дуслын усалгаа суурилуулах - Ус нөөцлөх сав 3 ширхэг, тус бүр нь 50,000 литрээс багагүй
--	--	--

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Үндсэн үзүүлэлтийн нэр	Ерөнхий шаардлагууд
1	Техникийн үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> ✓ Усалгааны системийг ус нөөцлөх сав бүрт насос /12,000 л/ц-с багагүй/, гол хоолой, туслах хоолой, цахилгаан хаалт, том болон нарийн хог шүүх 2 төрлийн филтртэйгээр суурилуулах ✓ Үндсэн хоолойн диаметр 50мм-с багагүй, ус юулэгч, хий авагчтай байх ✓ Үндсэн хоолойгоос туслах хоолойг эмээлээр холбох, эмээл бүр хаалттай байх ✓ Салаалсан хоолой бүр дээр тохирсон хаалттай, төгсгөлтэй байх ✓ Гоожууран усалгааны хоолой нь хатуу полиэтилен, хоолойн диаметр 20 мм-с багагүй, хананы зузаан 1,6 мм-с багагүй ✓ Гоожигч хошуу нь 4 л/цагаас багагүй зарцуулалттай, даралт тэнцүүлэгчтэй байх ✓ 10 бар түүнээс дээш даралтанд тэсвэртэй байх ✓ +40°C - 40°C градуст тэсвэртэй байх ✓ Үндсэн болон туслах хоолойнуудыг машин зам огтлон гарах байрлалд газарт булах  <ul style="list-style-type: none"> ✓ Дуслын хоолойн диаметр 16мм-с багагүй ✓ Ус зарцуулалт 2 л/ц-с багагүй ✓ Дуслуур хоорондын зайд 20 см хүртэл ✓ Ханын зузаан 1 мм-с багагүй ✓ 4 бар түүнээс дээш даралтанд тэсвэртэй ✓ +40°C - 40°C градуст тэсвэртэй ✓ Хөдөлгөөнгүй болгож газарт бэхлэх

		
2	Шаардлага	<ul style="list-style-type: none"> ✓ Нэг материал хийц ижил нэг төрөл, үйлдвэрийн байх ✓ Усалгааны системийн тоноглол, төхөөрөмж нь 5-с багагүй жилийн ашиглалт даах чанартай байх ✓ Усалгааны нормд тохирсон хүчин чадал бүхий насостай, филтертэй иж бүрэн автомат тохируулгатай гоожуурын усалгааны систем суурилуулах ✓ Усалгааны систем нь өгөгдсөн программтай удирдлагын хэрэгсэлтэй байх ✓ Үндсэн болон туслах хоолой нь полиэтилен материалыаар хийгдсэн хөнгөн, бат бөх, чанартай /PIPE/ хоолой байх ✓ Усалгааны худаг бүрийн гаргалгаанд усны тоолуур байрлуулах ✓ Төв болон салбар шугамын оролт бүр дээр хаалт тавих ✓ Цахилгаан техникийн төхөөрөмжүүдийг 220 кВ, 380 кВ хүчдэлийн цахилгаан тоног төхөөрөмжтэй байх ✓ Цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах, тус бүрт холболт, зангилааны хайрцаагтай байх ✓ Усалгааны системээр бордох ажиллагааг явуулах боломжтойгоор төлөвлөх ✓ Усалгааны системийн схем зураг, ажиллуулах гарын авлага боловсруулах

